



ЭРЧИМ ХҮЧНИЙ РЕФОРМЫН
ҮНДЭСНИЙ ХОРОО



ЭРЧИМ ХҮЧНИЙ
ЯАМ



“ЭРЧИМ ХҮЧНИЙ ШИЛЖИЛТ: ТЕХНОЛОГИ БА ЭКОЛОГИ (ЭХШТЭ-2025)” СЭДЭВТ ОЛОН УЛСЫН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРЛЫН УДИРДАМЖ

Байршил: Улаанбаатар, Монгол

Хугацаа: 2025 оны 6-р сарын 12-13 өдөр

Чухал огноо:

Материал хүлээн авах эцсийн хугацаа:	2025 оны 4-р сарын 30
Хүлээн авсан мэдэгдэл:	2025 оны 5-р сарын 07
Бүртгэлийн эцсийн хугацаа:	2025 оны 5-р сарын 26 хүртэл
Хурлын тов:	2025 оны 6-р сарын 12-13

Хуралд оролцох хэлбэр:

Биечлэн эсвэл виртуал байдлаар

НЭГ. ЗОРИЛГО

Анх удаа зохион байгуулагдаж буй “Эрчим хүчний шилжилт: технологи ба экологи (ЭХШТЭ-2025)” сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний хурал нь судлаачид, бодлого боловсруулагчид, салбарын мэргэжилтнүүдийн хувьд эрчим хүчний салбарт тулгамдаж буй сорилт, боломжуудын талаар ярилцаж, санал бодлоо солилцдог шинэ платформ байх болно. Энэхүү олон улсын эрдэм шинжилгээний хурал нь дэлхий дахин тогтвортой эрчим хүчний систем рүү шилжиж байгаа энэ үед эрчим хүчний аюулгүй байдал, байгаль орчны тогтвортой байдал, эдийн засгийн өсөлт зэрэг харилцан уялдаатай асуудлыг шийдвэрлэх хамтын ажиллагаа, инновац, мэдлэг солилцоог дэмжих зорилготой юм.

Монгол улсын Улаанбаатар хотод зохион байгуулагдаж буй энэхүү олон улсын эрдэм шинжилгээний хурал нь эрчим хүчний ирээдүйг тодорхойлж буй орчин үеийн техник технологи, бодлого зохицуулалтын хүрээ, экологийн асуудлыг хэлэлцэх зорилгоор салбаруудын мэргэжилтнүүдийг цуглуулах болно.

ХОЁР. ХАМРАХ ХҮРЭЭ

“Эрчим хүчний шилжилт: технологи ба экологи (ЭХШТЭ-2025)” олон улсын эрдэм шинжилгээний хурал нь эрчим хүчний шилжилт, эрчим хүчний салбарын шинэ техник технологи, экологийн асуудлуудтай холбоотой өргөн сэдвийн хүрээнд (судалгааны ажлын сэдэв үүгээр хязгаарлагдахгүй) зохион байгуулагдана.

Эрчим хүчний бодлого, төлөвлөлт ба эдийн засаг	Эрчим хүчний шинэ техник, технологи	Сэргээгдэх эрчим хүч ба экологийн асуудал
• Дэлхийн болон бүс нутгийн эрчим хүчний шилжилтийн стратеги;	• Эрчим хүч хуримтлуулах дэвшилтэт технологи ба сүлжээний интеграци;	• Нар, салхи, ус, газрын гүний дулааны эрчим хүчний дэвшил;

<ul style="list-style-type: none"> • Тогтвортой хөгжлийн зорилтууд (SDGs); • Сэргээгдэх эрчим хүчийг нэвтрүүлэх бодлогын хүрээ; • Тогтвортой эрчим хүчний системийн эдийн засгийн загварууд; • Эрчим хүчний аюулгүй байдал, геополитикийн асуудал; • Нүүрстөрөгчгүйжүүлэх стратеги; • Нүүрстөрөгчийн үнэ, ялгарлын худалдаа, ногоон татвар; • Хөгжиж буй эдийн засагтай орнуудын эрчим хүчний хүртээмж, тэгш байдал; • Цэвэр эрчим хүчний төслийн санхүүжилтийн механизм; 	<ul style="list-style-type: none"> • Эрчим хүчний систем дэх машин сургалт, өгөгдлийн шинжилгээ, хиймэл оюун, цахимжуулалт ба ухаалаг сүлжээ; • Эрчим хүчний үр ашиг ба хэмнэлт; • Төвлөрсөн бус эрчим хүчний систем; • Устөрөгчийн үйлдвэрлэл, хадгалалт, ашиглалт; • Нүүрстөрөгчийг барих, ашиглах, хадгалах технологи (CCUS); • Эрчим хүчний технологийн дэвшилтэт материал судлал; • Цөмийн эрчим хүчний хөгжил, аюулгүй байдал; • Түлшний элемент болон цахилгаан хөдөлгүүртэй тээврийн хэрэгсэл; 	<ul style="list-style-type: none"> • Эрчим хүчний хосолмол технологи; • Биомасс, хог хаягдлаас эрчим хүч үйлдвэрлэх технологи; • Уламжлалт дулааны цахилгаан станцын утааны хийг цэвэрлэх технологи; • Эрчим хүчний дэд бүтцийн хөгжлийн экологид үзүүлэх нөлөө; • Сэргээгдэх эрчим хүчний төслүүдэд биологийн олон янз байдлыг хамгаалах; • Уур амьсгалын өөрчлөлтийг бууруулах, дасан зохицох стратеги; • Тойрог эдийн засаг, нөөцийн тогтвортой менежмент;
---	--	--

ГУРАВ. ӨГҮҮЛЭЛД ТАВИГДАХ ШААРДЛАГА

Эрдэм шинжилгээний өгүүлэлд тавигдах үндсэн шаардлага:

- Сүүлийн жилүүдэд гүйцэтгэсэн судалгааны ажлын шинэлэг үр дүн байх;
- Урьд нь ямар нэг байдлаар хэвлэгдэж нийтлэгдээгүй бүтээл байх;
- Өгүүллийг **англи хэл** дээр стандарт хурлын загвар (IEEE-ийн хоёр баганат формат) ашиглан бэлтгэнэ. IEEE-ийн хурлын өгүүллийн гар бичмэлийн загварын холбоос- <https://www.ieee.org/conferences/publishing/templates.html>
- Хуудасны хязгаар: Энгийн өгүүллийн хувьд дээд тал нь 5 хуудас, 2 хуудас төлбөртэй нэмж болно.
- Илгээх арга: Цахим шуудангаар илгээнэ. Зохиогчид өгүүлээ бүрэн эхээр нь iteie.icet2025@gmail.com хаягаар илгээхийг урьж байна.
- Хянан магадлах процесс: Бүх ирүүлсэн өгүүллийг хуулалт шалгалт болон хөндлөнгийн шүүмжид оруулна.
- Хүлээн авсан өгүүлүүдийг хурлын эмхэтгэлд хэвлэх ба сонгогдсон өгүүлүүдийг олон улсын эрдэм шинжилгээний хурлын үеэр аман илтгэл байдлаар хэлэлцүүлнэ.

Өгүүлэл нь дараах дэс дараалалтай байна. Үүнд:

1. Хураангуй
2. Түлхүүр үг
3. Оршил (Судалгааны ажлын ач холбогдол тухайн сэдэв ямар түвшинд онцлог чухал болохыг дурдах, мөн судлагдсан байдал, зорилго, өгүүллийн бүтцийг багтаасан байна)
4. Судалгааны ажлын объектын тухай (судалгааны ажил гүйцэтгэсэн туршилтын объект, системийн тухай мэдээлэл)

- Судалгааны ажлын арга зүй (зохиогчийн дэвшүүлж буй шинэлэг санааг тусгасан байна)
- Судалгааны ажлын үр дүн (туршилт судалгааны үр дүнг тоон болон чанарын харьцуулалт хийж зураг, схем, хүснэгтээр нотлон тайлбарлаж бичих)
- Дүгнэлт (судалгааны ажлын ерөнхий дүгнэлт)
- Эшлэл (ашигласан эрдэм шинжилгээний өгүүлэл)

ДӨРӨВ. ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Энэхүү олон улсын эрдэм шинжилгээний хурлыг ШУТИС-ийн “Дулааны техник, үйлдвэрлэлийн экологийн хүрээлэн” зохион байгуулна.

“Эрчим хүчний шилжилт: технологи ба экологи (ЭХШТЭ-2025)” олон улсын эрдэм шинжилгээний хурлыг зохион байгуулах комисс:

Комиссын дарга:

ШУТИС-ийн ДТҮЭХ-ийн захирал: Академич, ШУ-ны доктор (Sc.D.)
Х.Энхжаргал (Sc.D.)

Ерөнхий зохион байгуулагч:

ШУТИС, ЭХС, ДТҮЭХ-ийн шинжлэх ухааны зөвлөх: Академич, ШУ-ны доктор (Sc.D.)
С.Батмөнх

Нарийн бичгийн дарга:

ШУТИС-ийн ДТҮЭХ-ийн эрдэмтэн нарийн бичгийн дарга: ШУ-ны доктор (Sc.D.)
Ж.Цэен-Ойдов

Техникийн хорооны гишүүд:

Доктор (Ph.D.)	Б.Одонхишиг
Доктор (Ph.D.)	З.Баттогтох
Доктор (Ph.D.)	Г.Пүрэвдорж
Доктор (Ph.D.)	Б.Намхайням
Доктор (Ph.D.)	Ц.Болортамир
Доктор (Ph.D.)	Ш.Энхбаяр
Доктор (Ph.D.)	Б.Баттөр
Магистр	Г.Одонтунгалаг
Магистр	М.Даваахүү
Магистр	Б.Оюуномин
Магистр	Х.Ганзолбоо
Магистр	Б.Батсүх-Очир
Магистр	Б.Туул
Магистр	М.Даваасамбуу
Магистр	Г.Уранцэцэг



NATIONAL ENERGY REFORM
COMMITTEE (NERC)



MINISTRY OF
ENERGY



INTERNATIONAL CONFERENCE ON ENERGY TRANSITION: TECHNOLOGY AND ECOLOGY (ICETTE-2025)

Venue: Ulaanbaatar, Mongolia

Dates: June 12–13, 2025

About the Conference

The International Conference on Energy Transition: Technology and Ecology (ICETTE-2025) is a premier global platform for researchers, policymakers, industry leaders, and environmental advocates to discuss and share insights on the pressing challenges and opportunities in the energy sector. As the world transitions toward sustainable energy systems, the conference aims to foster collaboration and innovation to address the intertwined issues of energy security, environmental sustainability, and economic growth.

Held in the vibrant city of Ulaanbaatar, Mongolia, ICETTE-2025 will bring together experts from diverse fields to explore cutting-edge technologies, policy frameworks, and ecological considerations that are shaping the future of energy.

Important Dates

Submission Deadline:	April 30, 2025
Acceptance Notification:	May 07, 2025
Registration Deadline:	May 26, 2025
Conference Dates:	June 12–13, 2025

Format for participating in this international conference:

In-person or virtually.

Submission Guidelines

- Please ensure that submissions are original and have not been published or submitted elsewhere.
- Paper Format: Papers should be prepared in **English**, using a standard conference template (e.g., IEEE two-column format). IEEE Conference proceedings manuscript template- <https://www.ieee.org/conferences/publishing/templates.html>
- Page Limit: Maximum of 5 pages for regular papers, with up to 2 additional pages allowed at a fee.
- Submission Method: Electronic submission via email. Authors are invited to submit their full papers via email to: iteie.icet2025@gmail.com
- Review Process: All submissions will undergo peer review.

- Accepted papers will be published in the conference proceedings and considered for presentation during the event.

Scope of the Conference

The conference will focus on three key thematic areas, each addressing critical aspects of the Energy Transition, New Energy Technologies, and Ecological Issues.

1. Energy Policy, Planning, and Economics	2. New Energy Technologies	3. Renewable Energy and Ecological Issues
<ul style="list-style-type: none"> • Global and regional energy transition strategies; • Sustainable development goals (SDGs); • Policy frameworks for renewable energy adoption; • Economic models for sustainable energy systems; • Energy security and geopolitical considerations; • Decarbonization strategies; • Carbon pricing, emissions trading, and green taxation; • Energy access and equity in developing economies; • Financing mechanisms for clean energy projects; 	<ul style="list-style-type: none"> • Advanced energy storage technologies and grid integration; • Smart grids, digitalization, machine learning, data analytics, and AI in energy systems; • Innovations in energy efficiency and conservation; • Decentralized Energy Systems; • Hydrogen production, storage, and utilization; • Carbon capture, utilization, and storage (CCUS); • Advanced materials for energy applications; • Nuclear energy development and safety; • Fuel cells and electric vehicles; 	<ul style="list-style-type: none"> • Advances in solar, wind, hydro, and geothermal energy; • Hybrid energy systems; • Bioenergy, biofuels and waste-to-energy technologies; • Ecological impacts of energy infrastructure development; • Flue gas cleaning technology; • Biodiversity conservation in renewable energy projects; • Climate change mitigation and adaptation strategies; • Circular economy and sustainable resource management;

Why Attend?

- **Global Networking:** Connect with leading experts, researchers, and policymakers from around the world.
- **Interdisciplinary Insights:** Gain a holistic understanding of the energy transition through diverse perspectives.
- **Cutting-Edge Research:** Explore the latest advancements in energy technologies and ecological solutions.
- **Policy Impact:** Contribute to shaping future energy policies and strategies.
- **Cultural Experience:** Immerse yourself in the rich culture and heritage of Mongolia while engaging in meaningful discussions.

Organized by: Institute of Thermal Engineering and Industrial Ecology, Mongolian University of Science and Technology (MUST).

Join Us in Ulaanbaatar!

Be part of this transformative dialogue on energy transition, new energy technologies, and ecological issues. Together, we can drive innovation, foster sustainability, and create a resilient energy future for generations to come.

We look forward to welcoming you to ICETTE-2025 in Ulaanbaatar, Mongolia!

Contact Information

For more details, please visit the official ICETTE-2025 website or contact the conference organizers directly.

Website: [*****]

For inquiries, please contact:

Email: iteie.icet2025@gmail.com

Phone: (+976)-99760644

Phone: (+976)-94490717

Phone: (+976)-99052142